



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

MONTHLY BULLETIN OF STATISTICS

2016/10



www.nso.mn govisumber.nso.mn www.1212.mn



www.1212.mn



**СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН
НЭГДСЭН САН**



www.nso.mn сайтын
Хэрэглэгийн бүртгэлд
бүртгүүлснээр
цахим хаягаар
тогтмол авч болно.



Monstat ezStat
аппликейшн



1900-1212



Лавлах утас

**Үндэсний
Статистикийн
хорооны
НОМЫН САН**

@statistic_mn



Статистик
мэдээлэл



Онлайн лавлах
мессенжер
8:30-17:30

СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЭЛ

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ

ХҮНД СУРТАЛ
АВЛИГА

ҮГҮЙ НЭЭЛТТЭЙ
ХҮРГЭНЭ



ГАРЧИГ

Ерөнхий тэмдэглэл	
Аргачлалын тайлбар.....	
I.Нийгмийн байдал.....	
II. Нийгмийн даатгал, халамж.....	
III.Эрүүл мэнд	
IV.Гэмт хэрэг	
V.Үнэ.....	
VI.Төсөв.....	
VIII.Хөдөө аж ахуй	
VIII. Аж үйлдвэр	
IXI.Тээвэр.....	
XI. Холбоо.....	
XII.Цаг агаарын мэдээ.....	
Хавсралт.....	



Ерөнхий тэмдэглэл

I. Товчилсон тэмдэглэл:

Сумдын нэр:

СҮ Сүмбэр

БТ Баянтал

ШГ Шивээговь

II. Саруудыг ром тоогоор тэмдэглэв. (I, II, III, IV, V, VI ...г.м)

Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдэх дүнг харуулахдаа I-IV, I-XII зэргээр илэрхийлэв.

III. Дараах тэмдэглэлийг ашиглав:

... Мэдээлэл байхгүй

0.0 Маш бага тоо+, - Зөрүү

- Гүйцэтгэл байхгүй* Дахин

"Үүнээс" гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

• Хөдөлмөр:

Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа Хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн хүмүүс орсон болно.

• Нийгмийн даатгал, халамж:

✓ Нийгмийн даатгалын сан нь ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах болон нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдэнэ. Нийгмийн даатгалын тухай хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг даатгуулагчаар тооцно.



✓ Тэтгэмж нь хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд даатгуулагчийн нийгмийн даатгалын сангаас нэг удаа олгох мөнгөн хөрөнгө байна. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай хүнд хуульд заасан тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээ, үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.

- **Эрүүл мэнд**

Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байвал хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүйгээр амьд төрөлтөнд тооцно.

✓ **1 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

✓ **1-5 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

- **Гэмт хэрэг:**

Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ. Гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд, хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

Эрүүгийн хууль шинэчлэгдсэнтэй холбогдон гэмт хэргийн нэр төрөл урьдынхаас нилээд өөрчлөгдсөн.

✓ Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт бусдыг амиа хорлоход хүргэх, иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг болон хүнийг санаатай алах, болгоомжгүйгээс алах хэргийг нэгтгэн оруулсан.

✓ Хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэгт хүчингийн хэргийг оруулсан.

✓ Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт бусдын эд хөрөнгийг хулгайлах, бусдын эд хөрөнгийг булаах, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах, бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх гэмт хэргийг хамруулсан.



✓ Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэгт гал түймрийн хэргийг хамруулсан.

✓ Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт танхайн гэмт хэргийг оруулсан.

- **Үнэ**

Хэрэглээний үнийн индекс /ХҮИ/ нь хэрэглэгчийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

Үндэсний статистикийн хороо нь хэрэглээний үнийн улсын индексийг Улаанбаатар хотын ХҮИ-ээр тооцож байсан аргачлалаа шинэчилж, 2008 оны 1 дүгээр сараас олон улсын нийтлэг арга зүйн дагуу хэрэглээний үнийн улсын индексийг аймаг, нийслэлийн өрхийн 2010 оны хэрэглээний зардлаар жигнэсэн дундаж үзүүлэлтээр тооцох аргачлалд шилжсэн.

- **Төсөв санхүү:**

Аймгийн төсвийн мэдээг Санхүү, төрийн сангийн хэлтэс үндсэн нэгжүүдээс авч нэгтгэн ирүүлдэг.

- **Хөдөө аж ахуй:**

Мал төллөлт, төл бойжилт, мал хорогдлын мэдээг багийн Засаг дарга нар хариуцан цуглуулж, сумын Тамгын газарт нэгтгэн ирүүлдэг.

✓ Төл бойжилтын хувийг тооцохдоо бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулж, 100-гаар үржүүлнэ.

✓ Зүй бусаар хорогдсон малын тоонд халдвартай, халдваргүй өвчин, зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг гэнэтийн аюул, хариулга, маллагаатай холбоотой бусад шалтгаанаар хорогдсон малыг хамруулна.

- **Аж үйлдвэр:**

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл нь аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна.



Говьсүмбэр аймгийн нийгэм, эдийн засгийн байдал

(2016 оны эхний 10 сарын байдлаар)



I. Нийгмийн байдал

I.1 Бүртгэлтэй ажилгүй иргэн


Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил хайгч ажилгүй иргэдийн тоо 2016 оны 10 сард 313 байгаагийн 214 нь эмэгтэйчүүд байна. Ажил хайгч ажилгүй иргэдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 121 буюу 27.9 хувиар, өмнөх сарынхаас 2 буюу 0.6 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Эхний 10 сард Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газарт 99 ажлын байрны захиалга ирсэн нь өмнөх сараас 1 буюу 1.0 хувиар өссөн, өмнөх оны мөн үеэс 254 буюу 72.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хөдөлмөр халамж, үйлчилгээний газраар эхний 10 сард 25 иргэн ажилд зуучлуулсны 17 нь буюу 68.0 хувь эмэгтэйчүүд байлаа. Ажилд зуучилсан иргэдийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал 8.2 дахин буурсан ба өмнөх сартай харьцуулахад ижил түвшинд байна.

Зураг.I.1

Хөдөлмөр халамж, үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил хайгч иргэн, үүнээс эмэгтэй, жил бүрийн эхний 10 дугаар сарын байдлаар



Ажил хайгч иргэдийг насны бүлгээр нь авч үзвэл 15-24 насны 81, 25-34 насны 115, 35-44 насны 63, 45-54 насны 49, 55-59 насны 5 иргэн байна.




I.2 Ердийн хөдөлгөөн

Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2016 оны эхний 10 сарын байдлаар 400 эх амаржиж, 406 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеийнхээс амаржсан эхийн тоо 43 буюу 13.2 хувиар, төрсөн хүүхдийн тоо 45 буюу 12.5 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Мөн нас баралт 93, бүртгүүлсэн гэр бүл 70, цуцалсан гэр бүл 18, үрчлэгдсэн хүүхэд 5 байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс нас баралт 21 буюу 29.2 хувиар, бүртгүүлсэн гэр бүл 1 буюу 1.4 хувиар тус тус өсч, цуцалсан гэр бүлийн тоо өмнөх оны мөн үеэс 2 буюу 10.0 хувиар, үрчлэгдсэн хүүхдийн тоо 1 буюу 16.7 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Зураг.I.2

Шинэ төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн эхний 10 сарын байдлаар



II. Нийгмийн даатгал, халамж

II.1 Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын сангийн орлого 2016 оны эхний 10 сард 6321.3 сая төгрөг, зарлага 7372.4 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс орлого 135.2 сая төгрөг буюу 2.2 хувиар, зарлага 127.2 сая төгрөг буюу 1.8 хувиар тус тус өслөө.

Нийгмийн даатгалын сангийн орлого 2016 оны эхний 10 сард өмнөх оны мөн үеийнхээс 135.2 сая төгрөгөөр нэмэгдэхэд тэтгэврийн орлого 137.6 сая төгрөг буюу 3.6 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Нийгмийн даатгалын сангийн зарлага 2016 оны эхний 10 сард өмнөх оны мөн үеийнхээс 127.2 сая төгрөгөөр өсөхөд тэтгэвэрийн сангийн зарлага 487.2 сая төгрөг буюу 9.6 хувиар өссөн нь голлон нөлөөлөв.



II.2 Нийгмийн халамж

Нийгмийн халамжийн сангаас 2016 оны эхний 10 сард 4559 хүнд 1070.6 сая төгрөгийн нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлсэн бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс нийгмийн халамж авагчдын тоо 629 хүн буюу 16.0 хувиар, олгосон нийгмийн халамжийн сан 54.3 сая төгрөг буюу 5.3 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

✓ Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид 2016 оны эхний 10 сард 1444 хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс 73 хүн буюу 5.3 хувиар, олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ 33.8 сая төгрөг буюу 5.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

✓ Нийгмийн халамжийн үйлчилгээ хөнгөлөлт, тусламжид 2016 оны эхний 10 сард 3115 хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс 556 хүн буюу 21.7 хувиар, олгосон халамж үйлчилгээ хөнгөлөлт, тусламж 20.5 сая төгрөг буюу 5.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.


II.3 Дундаж цалин

Аймгийн Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын хэлтсийн эхний 10 сарын мэдээгээр 191 байгууллагын 5699 даатгуулагч иргэн, үүнээс 997 нь сайн дурын даатгуулагч байна. Нийт даатгуулагчдын цалин өссөн дүнгээр 31406.4 сая төгрөг байгаа бол сарын дундаж цалин сайн дурын даатгуулагч ороогүй дүнгээр 645.0 мянган төгрөг байна.

Ажиллагсдын цалинг аж ахуйн нэгж байгууллагын хариуцлагын хэлбэрээр авч үзвэл төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой 21 аж ахуйн нэгж, байгууллагын 1213 ажилтны дундаж цалин нь 812.3 мянган төгрөг, төсөвт 56 байгууллагын 1692 ажилтны дундаж цалин нь 610.6 мянган төгрөг, 7 ХКомпанийн 657 ажилтны дундаж цалин нь 983.8 мянган төгрөг, 85 ХХКомпанийн 927 ажилтны дундаж цалин нь 331.3 мянган төгрөг, бусад 22 байгууллагын 213 ажилтны дундаж цалин нь 293.8 мянган төгрөг боллоо.

Зураг II.1

Нийгмийн даатгалын даатгуулагчийн тоо, 2016 оны эхний 10 сарын байдлаар






III. Эрүүл мэнд



Эрүүл мэндийн газраас эрхлэн гаргадаг мэдээгээр 2016 оны эхний 10 сарын байдлаар 384 эх амаржиж 2015 оны мөн үетэй харьцуулахад 21 буюу 5.8 хувиар төрөлт нэмэгдсэн байна. Амьд төрсөн хүүхэд 387 үүнээс 193 нь хүү, 194 нь охин байна. Өмнөх оны мөн үеийнхээс амьд төрсөн хүүхэд 22 буюу 6.0 хувиар тус тус өссөн байна.

Амаржсан эх, амьд төрсөн хүүхэд, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Зураг III.1




0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 6 ба 1000 амьд төрөлтөд 15.5 ногдож байгаа нь өмнөх оны мөн үеэс 4.6 промиллоор нэмэгдсэн, 1-5 хүртэл насны хүүхдийн эндэгдэл 2 тохиолдол бүртгэгдсэн байна.

Халдварт өвчин эхний 10 сарын байдлаар 267 буюу 10000 хүн амд 160.2 байгаа нь өмнөх оны мөн үеэс 163 тохиолдлоор нэмэгдэж, нийт өвчлөлд улаан бурхан өвчин нь 52.4 хувийг эзэлж байна.

Зураг III.2

Нас баралт, жил бүрийн эхний 10 сарын байдлаар






Он гарсаар 106155 хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 12822 буюу 13.7 хувиар, 4116 хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 373 буюу 10.0 хувиар тус тус өссөн байна.

2016 оны эхний 10 сарын байдлаар түргэн тусламжийн дуудлага 5487, халдварт өвчин 267 бүртгэгдсэн байна.

Зураг III.3

Амьгүй төрөлт болон нялхасын эндэгдэл,
жил бүрийн эхний 10 сарын байдлаар




IV. Гэмт хэрэг

Аймгийн Цагдаагийн хэлтсийн мэдээгээр 2016 оны эхний 10 сард 168 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 5 буюу 2.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Зураг IV.1

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо,
жил бүрийн эхний 10 сарын байдлаар



Өмнөх оны мөн үеийнхээс нийт гэмт хэргийн тоо буурахад нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 4 буюу 36.4 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.




Илрээгүй гэмт хэргийн тоо 21, гэмт хэрэг илрүүлэлтийн хувь 75 болсон нь илрээгүй гэмт хэрэг өмнөх оны мөн үеийнхээс 12.5 хувиар, илрүүлэлтийн хувь 0.1 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

Гэмт хэргийн улмаас 144 хүн гэмтэж, 20 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеийнхээс гэмтсэн хүний тоо 58 буюу 28.7 хувиар буурч, нас барсан хүний тоо 1 буюу 5.3 хувиар өссөн байна.

Зураг IV.2

Гэмт хэргийн ангилал,
жил бүрийн эхний 10 сарын байдлаар




Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2016 оны 10 сарын байдлаар 352 сая төг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 271 сая төг болж, өмнөх оны мөн үеийнхээс учирсан хохирлын хэмжээ 662 сая төгрөгөөр буюу 2.9 дахин, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 65 сая төгрөг буюу 19.4 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

2016 оны эхний 10 сард 743 хүн эрүүлжүүлэгдэж, 15 хүн баривчлагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс эрүүлжүүлэгдсэн хүний тоо 213 буюу 22.3 хувиар, баривчлагдсан хүний тоо 114 буюу 8.6 дахин буурсан байна.



Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо
жил бүрийн эхний 10 сарын байдлаар



V. Хэрэглээний үнийн индекс

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрлөөр өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ аймгийн хэмжээнд 2016 оны 10 дугаар сард өмнөх сарынхаас 2.7 пунктээр буурч, өмнөх оны мөн үеийнхээс 3.9 пунктээр, жилийн эцсийнхээс 3.7 пунктээр тус тус буурсан байна.

Хэрэглээний үнийн индекс, 2016 оны 10 дугаар сард, бүлгийн дүнгээр

Бараа үйлчилгээний бүлэг	2016.X	2016.X	2016.X
	2015.X	2015.XII	2016.IX
Ерөнхий индекс	102.4	102.2	98.5
Хүнсний бараа, ундаа, ус	98.9	98.6	91.6
Согтууруулах ундаа, тамхи	101.0	101.1	100.0
Хувцас, бөс бараа, гутал	105.5	105.5	100.0
Орон сууц, ус, цахилгаан, түлш	107.3	106.7	109.2
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	101.8	101.4	100.0
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	103.0	103.0	100.5
Тээвэр	97.0	97.3	99.9
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	100.0	100.0	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	97.8	97.8	100.0
Боловсролын үйлчилгээ	100.0	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байр	124.9	124.9	100.0
Бусад бараа, үйлчилгээ	101.1	101.1	101.0



VII. Орон нутгийн төсөв


2016 оны эхний 10 сарын байдлаар орон нутгийн төсвийн нийт орлогын төлөвлөгөө 20761.3 сая төгрөг, гүйцэтгэлээр 21086.9 сая төгрөг болж орлогын төлөвлөгөө 101.6 хувийн биелэлттэй байна.

Аймгийн төсвийн нийт зарлага 13946.2 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 11754.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй 2192.2 сая төгрөгийн хэмнэлттэй байна.

2016 оны эхний 10 сарын байдлаар авлагын үлдэгдэл 15.9 сая төгрөг, өглөгийн үлдэгдэл 217.0 сая төгрөг байна.

Зураг VI.1

Орон нутгийн төсвийн орлого, зарлага, жил бүрийн
эхний 10 сарын байдлаар, сая төгрөгөөр



VIII. Мал аж ахуй


Аймгийн хэмжээнд 2015 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 171188 хээлтэгч малын 151504 буюу 88.5 хувь нь төллөсөн байна. Эм хонины 92.2 хувь, эм ямааны 86.5 хувь, үнээний 81.9 хувь, ингэний 52.4 хувь, гүүний 74.2 хувь нь төллөсөн бөгөөд 2016 оны 10 сарын байдлаар 149294 толгой төл бойжиж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 17281 толгойгоор өссөн үзүүлэлттэй байна. Төл бойжилт 97.8 хувьтай байна.

2016 оны эхний 10 сард том малын зүй бус хорогдол 11488 болж, өмнөх оны мөн үеийнхээс 105686 толгойгоор өссөн байна. Нийт хорогдолд өвчнөөр хорогдсон 23 мал, хорогдсон хээлтэгч 3617 байна.




Зураг VIII.1

Төл бойжилт, жил бүрийн эхний 10 сараар, толгойгоор



Зураг VIII.2

Хорогдсон хээлтэгч, жил бүрийн эхний 10 сараар, толгойгоор

**Газар тариалан***Тариалалт*

2016 оны тариалалтын эцсийн мэдээгээр 51.2 га талбайд тариалалт хийснээс төмс 22.9 га-д, хүнсний ногоо 18.2 га-д, тэжээлийн ургамал 10.6 га-д тариалсан байна. Өмнөх оны мөн үеийнхээс нийт тариалсан талбай 25.3 га буюу 97.7 хувиар их байгаагаас төмсний талбай 14.6 га буюу 2.7 дахин, тэжээлийн ургамлын талбай 8.8 га буюу 7.3 дахин, хүнсний ногооны талбай 2 га буюу 12.3 хувиар нэмэгдсэн байна.

Ургац хураалт

Ургац хураалтын явцын мэдээгээр аймгийн хэмжээнд 10 сарын 30-ны байдлаар 97.7 тн төмс, 117.4 тн хүнсний ногоо хурааж, 1390.1 тн өвс бэлтгэсэн нь өмнөх оны мөн



үеийнхээс төмс 48.3 тн-оор буюу 97.8 хувиар, хүнсний ногоо 15.4 тн-оор буюу 13.9 хувиар, бэлтгэсэн өвс 257.3 тн-оор буюу 22.7 хувиар тус тус өссөн байна.




VIII. Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын нийт гаргалт 2016 оны эхний 10 сард 35552.1 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс 5795.2 сая төгрөг буюу 20.2 хувиар өссөн ба үүнд уул уурхайн салбарын гаргалт нь 5928.9 сая төг буюу 21.0 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна. Оны үнээр 33745.5 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 4229.8 сая төгрөг буюу 14.3 хувиар өслөө.

Шивээ-Овоо ХК нь нийт борлуулалтын 95.9 хувь буюу 32.4 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн байна.

Зураг VIII.1

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, салбараар,
жил бүрийн эхний 10 сар, сая төгрөгөөр



IX.ТЭЭВЭР

Авто тээврийн үндэсний төвийн 2016 оны эхний 10 сарын мэдээгээр 20.0 мянган зорчигч тээвэрлэж, зорчигч эргэлт 4550.2 мян.хүн км болж, 13 ажилтантай 11.7 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал зорчигч тээвэрлэлт 6.4 хувиар, зорчигч эргэлт 8.4 хувиар, тээврийн орлого 3.6 хувиар тус тус өссөн үзүүлэлт гарлаа.




Х. ХОЛБОО

Аймгийн холбооны газрын мэдээгээр 2016 оны эхний 10 сарын байдлаар нийт орлого 167.3 сая төгрөг болж өмнөх оны мөн үеийнхээс 14.7 сая төг буюу 8.1 хувиар буурчээ. Нийт орлогод хүн амаас орсон орлого 100.5 сая төг буюу 60.1 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс 0.6 сая төг буюу 0.6 хувиар өссөн байна. Аймгийн хэмжээнд нийт суурин телефон цэгийн тоо 343 болж өмнөх оны мөн үеийнхээс 50 буюу 12.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

2016 оны эхний 10 сарын байдлаар интернет үйлчилгээний цэгийн тоо 1 байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 2 дахин багассан үзүүлэлттэй байна. Интернет үйлчилгээний цэгээр үйлчлүүлэгчийн тоо 208 үүнээс байнгын хэрэглэгчийн тоо 65 байна.

Зураг Х.1

Холбооны нийт орлого, үүнээс хүн амаас орсон орлого,
жил бүрийн эхний 10 сар, мянган төгрөгөөр



XI. Цаг агаарын мэдээ

Хур тунадас: Энэ сард нийт 11.3 мм хур тунадас орсон.

Салхи: Ихэнх хугацаанд секундэд 5-11 метр байсан.

Агаарын температур: 10-р сарын 1-р арав хоног болон 2-р 10 хоногийн дунд болон сүүлээр шөнөдөө 3 градус хүйтнээс 2 градус дулаан, өдөртөө 11-16 градус дулаан, 2-р арав хоногийн эхэн болон 3-р арав хоногийн эхэн үеэр шөнөдөө 3-8 градус хүйтэн, өдөртөө 2-7 градус дулаан, бусад хугацаанд шөнөдөө 14-19 градус хүйтэн, өдөртөө 4-8 градус хүйтэн байсан. Хамгийн дулаан нь 2-ны өдөр 16.0 градус дулаан, хамгийн хүйтэн нь 30-ны шөнө 19.6 градус хүйтэн байсан байна.



2016 оны 11 дүгээр сарын ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВ

Агаарын температурын сарын дундаж 1-6 градус хүйтэн бөгөөд олон жилийн дунджаас 0.5-1.0 градусаар дулаан байна.

1-р арав хоногийн эхээр шөнөдөө 4-9 градус хүйтэн, өдөртөө 4-9 градус дулаан байна. 1-р арав хоногийн дунд үе болон эцэс, 2-р арав хоног, 3-р арав хоногийн эхээр шөнөдөө 11-16 градус хүйтэн, өдөртөө 2 градус хүйтнээс 3 градус дулаан байна. 3-р арав хоногийн сүүлийн хагаст хүйтэрч шөнөдөө 19-24 градус, өдөртөө 8-13 градус хүйтэн байна.

Хур тунадасны хэмжээ олон жилийн дунджийн орчим байх төлөвтэй. 1 ба 2-р арав хоногийн дунд үе, 2-р арав хоногийн эхээр зарим газраар цас, 1-р арав хоногийн сүүлч, 2-р арав хоногийн дунд үеэр бага зэргийн цас орох төлөвтэй.



ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

	Хэмжих нэгж	2015 X	2016 X	$\frac{2016 X}{2015 X} \%$
Нийгмийн статистикийн үзүүлэлтүүд				
Төрсөн хүүхдийн тоо (амьд төрөлт)	хүн	365	387	106.0
Ажил хайгч иргэдийн тоо, 10 дугаар сарын эцэст	хүн	434	250	57.6
Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо	хүн	104	267	2.6 дахин
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	173	168	97.1
Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт				
Орон нутгийн төсвийн орлого	сая.төг	10466.3	21086.9	2.0 дахин
Татварын орлого	сая.төг	2691.9	3446.8	128.0
Татварын бус орлого	сая.төг	333.8	543.6	162.9
Хөрөнгийн орлого	сая.төг	0.7	196.3	-
Тусламжийн орлого	сая.төг	7439.9	8450.1	113.6
Орон нутгийн төсвийн зарлага	сая.төг	10643.4	11754.0	110.4
Авлага	сая.төг	6.3	15.9	2.5 дахин
Өглөг	сая.төг	273.2	217.0	79.4
Эдийн засгийн үзүүлэлтүүд				
Том малын зүй бусын хорогдол	тол	902	11488	12.7 дахин
- Тэмээ	тол	1	1	100.0
- Адуу	тол	22	305	13.9 дахин
- Үхэр	тол	38	474	12.5 дахин
- Хонь	тол	358	4098	11.4 дахин
- Ямаа	тол	483	6610	13.7 дахин
Бойжуулсан төл	тол	132013	149294	113.1
- Тэмээ	тол	150	181	120.7
- Адуу	тол	3648	4190	114.6
- Үхэр	тол	3291	3972	120.7
- Хонь	тол	61812	72343	117.0
- Ямаа	тол	63112	68608	108.7
Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний нийт гаргалт	сая.төг	29576.9	35552.1	120.2
Тээврийн орлого	сая.төг	8.1	11.7	144.4
Холбооны орлого	сая.төг	182.0	167.3	91.9



I.1 ШИНЭ АЖЛЫН БАЙРНЫ МЭДЭЭ, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Үзүүлэлтүүд	2015 X	2016 X	$\frac{2016 X}{2015 X} \%$
Ажил хайгч <u>иргэнийн</u> тоо	434	313	72.1
Үүнээс эмэгтэй	250	214	85.6
Ажлын байрны захиалга	353	99	28.0
Ажилд <u>жуучлагдсан</u> иргэд	205	25	12.2
Үүнээс эмэгтэй	115	17	14.8

II.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, төрлөөр, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Сангийн төрөл	2015 X	2016 X	$\frac{2016 X}{2015 X} \%$
Нийгмийн даатгалын сангийн орлого, сая.төг	6186.2	6321.3	102.2
Тэтгэврийн даатгалын сангийн	3797.4	3935.0	103.6
Тэтгэмжийн даатгалын сангийн	442.5	449.4	101.6
Эрүүл мэндийн даатгалын сангийн	1227.1	1232.7	100.5
<u>ҮОМШӨ*</u> -ний даатгалын сангийн	613.0	594.2	96.9
<u>Ажилгүйдлын</u> даатгалын сангийн	90.6	91.7	101.2
Нийгмийн даатгалын сангийн зарлага, сая.төг	7245.2	7372.4	101.8
Тэтгэврийн даатгалын сангийн	5093.2	5580.4	109.6
Тэтгэмжийн даатгалын сангийн	493.4	467.6	94.8
Эрүүл мэндийн даатгалын сангийн	1199.9	948.1	79.0
<u>ҮОМШӨ*</u> -ний даатгалын сангийн	260.6	238.5	91.5
<u>Ажилгүйдлын</u> даатгалын сангийн	198.2	137.8	69.5

Тайлбар: *ҮОМШӨ –Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин



II.2 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮН, ОЛГОСОН ТЭТГЭВЭР, 2016 оны 10 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2015 Х		2016 Х		$\frac{2016 \text{ Х}}{2015 \text{ Х}}\%$	
	Хүн тоо	Дүн	Хүн тоо	Дүн	Хүн тоо	Дүн
Нийгмийн халамжийн сангийн дүн	3930	1016.3	4559	1070.6	116.0	105.3
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	1371	636.3	1444	670.1	105.3	105.3
Халамжийн тэтгэвэр	295	316.5	335	322.8	111.6	102.3
Нөхцөлт мөнгөн тэтгэмж / Үүнээс: /	1076	319.9	1109	347.3	103.1	108.6
Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн тэтгэмж	788	166.6	801	173.1	101.6	103.9
Ахмад настныг асарч буй иргэний асаргааны тэтгэмж	127	55.3	140	63.9	110.2	115.6
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэний асаргааны тэтгэмж	138	84.2	147	97.8	106.5	116.2
Бүтэн өнчин хүүхэд үрчлэн өсгөсөн, асарч буй иргэний тэтгэмж	23	13.8	21	12.4	91.3	89.9
Нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлт тусламж	2559	380.0	3115	400.5	121.7	105.4
Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	719	69.1	680	62.9	94.6	91.0
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	164	34.4	281	64.2	171.9	186.6
Нийгмийн халамжийн үйлчилгээ	282	45.8	468	34.3	166.0	74.9
Нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт тусламж мөнгөн тусламж	231	55.6	496	66.0	214.7	118.7
Алдарт цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	12	15.1	7	11.3	58.3	74.8
Алдарт эхийн одонтой эхчүүдэд үзүүлэх мөнгөн тусламж	1151	160.1	1183	161.7	102.8	101.0



III.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Үзүүлэлт	2015 X	2016 X	$\frac{2016 X}{2015 X} \%$
Төрсөн эх	363	384	105.8
Амьд төрсөн хүүхэд	365	387	106.0
Эрэгтэй	177	193	109.0
Эмэгтэй	188	194	103.2
Амьгүй төрөлт	2	2	100.0
Нийт нас баралт	64	60	93.8
Эмнэлгийн нас баралт	9	14	155.6
Хоног болоогүй нас баралт	4	8	2 дахин
0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	4	6	150.0
5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	5	8	160.0
Эмчлэгдсэн өвчтөн	3743	4116	110.0
Амбулаторийн үзлэг	93333	106155	113.7
Халдварт өвчин	104	267	2.6 дахин



IV.1 ЭРҮҮГИЙН БОЛОН ХЭВ ЖУРМЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН МЭДЭЭ , төрлөөр

Үзүүлэлт	2015 X	2016 X	$\frac{2016 X}{2015 X} \%$
Бүртгэгдсэн гэмт хэрэг	173	168	-2.9
Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг	71	77	8.5
Өмчлөх эрхийн эсрэг	63	57	-9.5
Нийгмийн аюулгүй байдлын эсрэг	11	7	-36.4
Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	17	11	-35.0
Хүүхэд гэр бүлийн нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг	3	4	33.0
Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	0	7	7 нэгж
Захиргааны журмын эсрэг гэмт хэрэг	6	-	-6 нэгж
Аж ахуйн эсрэг гэмт хэрэг	1	1	-
Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг	1	1	-
Албан тушаалтны эсрэг гэмт хэрэг	0	2	2 нэгж
Иргэдийн улс төрийн болон бусад эрх эрх чөлөөний эсрэг гэмт	1	1	-
Гэмт хэрэгт холбогдогсод	174	172	-1.1
15 хүртэлх насны	1	1	-
16-17 насны	6	6	-
18-29 насны	59	75	27.0
30-34 насны	27	35	30.0
35-с дээш	81	55	-32.0
Боловсрол – Дээд	33	30	-9.0
Боловсрол - Тусгай дунд	11	18	64.0
Боловсрол – Бүрэн дунд	61	64	5.0
Боловсрол – Бүрэн бус дунд	45	32	-29.0
Боловсрол – Бага	18	19	6.0
Боловсролгүй	6	8	33.0
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдсэн	18	5	-72.0
Ажилгүй иргэд үйлдсэн	70	75	7.0
Эмэгтэй хүн оролцсон	30	32	6.6
Хүүхэд оролцсон	7	6	-14.0
Бүлгээр үйлдсэн	22	25	14.0
Согтуугаар үйлдсэн	75	60	-20.0
Гэмт хэргийн гаралт, нөхцөл байдал	173	168	-2.9
Гудамж талбайд	50	44	-12.0
Албан газарт	15	26	73.0
Гэр орон сууцанд	48	52	8.3
Авто зам	16	11	-31.3
Бусад газарт	42	33	-21.4
ГХ-н улмаас нас барсан	19	20	5.3
ГХ-н улмаас гэмтсэн	202	144	-28.7
Учирсан хохирол / сая.төг /	1014	352	-65.3
Нөхөн төлүүлсэн хохирол / сая.төг /	336	271	-19.4



VI.1 ТӨСВИЙН ОРЛОГО, үзүүлэлтүүдээр, жил бүрийн эхний 10 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2015 X	2016 X	$\frac{2016 X}{2015 X} \%$
Орон нутгийн орлого	10466.3	21086.9	2.0 дахин
Татварын орлого	2691.9	3446.8	128.4
Орлогын албан татвар	2087.7	2397.0	114.8
Өмчийн татвар	249.8	280.1	112.1
Дотоодын бараа үйлчилгээний	-	-	-
Бусад	354.4	962.0	2.7 дахин
Татварын бус орлого	333.8	543.6	162.9
Хөрөнгийн орлого	0.7	3.9	5.6 дахин
Тусламжийн орлого	7439.9	8450.1	113.6

VI.2 ТӨСВИЙН ЗАРЛАГА, үзүүлэлтүүдээр, жил бүрийн эхний 10 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2015 X	2016 X	$\frac{2016 X}{2015 X} \%$
Бүх зарлага	10643.4	11754.0	107.2
Бараа үйлчилгээний зардал	8452.9	8857.0	104.8
Нийгмийн халамжийн үйлчилгээний зардал	983.0	973.3	99.0
Хөрөнгийн зардал	1207.5	1923.6	159.3
Төсөвт байгууллагын тоо	47	47	100.0
Төсөвт байгууллагын ажиллагсдын тоо	751	751	100.0

VI.3 ТӨСВИЙН ӨГЛӨГ, АВЛАГЫН ҮЛДЭГДЭЛ, үзүүлэлтүүдээр, жил бүрийн эхний 10 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2015 X	2016 X	$\frac{2016 X}{2015 X} \%$
Авлага	6.3	15.9	2.5 дахин
Өглөг	273.2	217.0	79.4



VIII.1 МАЛ ТӨЛЛӨЛТ, эх малын төрлөөр, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Төрөл	2015 X	2016 X	$\frac{2016 X}{2015 X} \%$
Бүгд	131685	151504	115.1
Ингэ	158	193	122.2
Гүү	3682	4247	115.3
Үнээ	3338	4122	123.5
Эм хонь	62056	73144	117.9
Эм ямаа	62451	69798	111.8

VIII.2 ТӨЛЛӨСӨН ХЭЭЛТЭГЧ сумдаар, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Сумд	2015 X	2016 X	$\frac{2016 X}{2015 X} \%$
Дүн	131685	151504	115.1
<u>Баянтал</u>	24208	23933	98.9
Сүмбэр	91001	112612	123.7
<u>Шивээговь</u>	16476	14959	90.8

VIII.3 БОЙЖСОН ТӨЛ, төлийн төрлөөр, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Төрөл	2015 X	2016 X	$\frac{2016 X}{2015 X} \%$
Бүгд	132013	149294	113.1
Ботго	150	181	120.6
Унага	3648	4190	114.9
Тугал	3291	3972	120.7
Хурга	61812	72343	117.0
Ишиг	63112	68608	108.7

VIII.4 БОЙЖСОН ТӨЛ, сумдаар, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Сумд	2015 X	2016 X	$\frac{2016 X}{2015 X} \%$
Дүн	132013	148455	113.1
<u>Баянтал</u>	24516	23786	97.0
Сүмбэр	91020	110818	121.8
<u>Шивээговь</u>	16477	14690	89.2



VIII.5 ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН ТОМ МАЛ, малын төрлөөр, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Төрөл	2015 Х	2016 Х	$\frac{2016 \text{ Х}}{2015 \text{ Х}}\%$
Бүгд	902	11488	12.7 дахин
Тэмээ	1	1	100.0
Адуу	22	305	13.9 дахин
Үхэр	38	474	12.5 дахин
Хонь	358	4098	11.4 дахин
Ямаа	483	6610	13.7 дахин

VIII.6 ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН ТОМ МАЛ, сумдаар, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Сумд	2015 Х	2016 Х	$\frac{2016 \text{ Х}}{2015 \text{ Х}}\%$
Дүн	902	11488	12.7 дахин
<u>Баянтал</u>	46	1981	43.0 дахин
Сүмбэр	770	6508	8.5 дахин
<u>Шивээговь</u>	86	2999	34.9 дахин

VIII.7 ХОРОГДСОН ХЭЭЛТЭГЧ МАЛ, малын төрлөөр, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Төрөл	2015 Х	2016 Х	$\frac{2016 \text{ Х}}{2015 \text{ Х}}\%$
Бүгд	367	3617	9.9 дахин
Тэмээ	-	-	-
Адуу	2	213	111.4 дахин
Үхэр	10	168	16.8 дахин
Хонь	149	1383	9.3 дахин
Ямаа	206	1853	9.0 дахин

VIII.8 ХОРОГДСОН ХЭЭЛТЭГЧ МАЛ, сумдаар, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Сумд	2015 Х	2016 Х	$\frac{2016 \text{ Х}}{2015 \text{ Х}}\%$
Дүн	367	3617	9.9 дахин
<u>Баянтал</u>	28	158	5.6 дахин
Сүмбэр	304	700	2.3 дахин
<u>Шивээговь</u>	35	2759	78.8 дахин



VIII.1 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн гаргалт жил бүрийн эхний 10 сар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2015 X	2016 X	$\frac{2016 X}{2015 X} \%$
Нийт	29576.9	35552.1	120.2
Уул уурхайн нийт гаргалт	28226.7	34155.6	121.0
Сувагжуулалт	56.2	62.5	111.2
Дулаан	1153.2	1174.7	101.9
Усан хангамж	140.8	159.2	113.1

VIII.2 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт, жил бүрийн эхний 10 сар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2015 X	2016 X	$\frac{2016 X}{2015 X} \%$
Нийт	29515.7	33745.5	114.3
Уул уурхай	28165.6	32349.1	114.6
Дулааны эрчим хүч, усан хангамж, сувагжуулалт	1350.2	1396.4	103.4
Дулаан	1153.2	1174.7	101.9
Цэвэр ус	197.0	221.7	112.5

VIII.3 Уул уурхайн салбарын бүтээгдэхүүний нийт үзүүлэлтүүд, Шивээ-Овоо ХК жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Үзүүлэлт	2015 X	2016 X	$\frac{2016 X}{2015 X} \%$
Нийт борлуулалт /Үнийн дүнгээр, сая.төг/	28165.6	32349.1	114.6
Нүүрс борлуулалт /биет хэмжээ, мян.тн/	1725.5	1409.6	81.7
Нүүрс гаргалт /биет хэмжээ, мян.тн/	1397.5	1484.9	106.3
Ажиллагсдын тоо	515	595	115.6



IX.1 Авто тээврийн газрын үзүүлэлт, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Үзүүлэлт	Нэгж	2015 Х	2016 Х	$\frac{2016 \text{ Х}}{2015 \text{ Х}}\%$
Тээврийн орлого	Мян.төг	10339.9	11726.2	113.4
Зорчигч эргэлт	Мян.хүн км	4512.0	4550.2	100.8
Зорчигчдын тоо	Мян.хүн	18.8	20.0	106.4
Ажиллагсдын тоо	тоо	11	13	118.2

X.1 Аймгийн холбооны газрын үзүүлэлт, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Үзүүлэлт	нэгж	2015 Х	2016 Х	$\frac{2016 \text{ Х}}{2015 \text{ Х}}\%$
Нийт орлого	мян.төг	182013.8	167322.0	91.9
Үүнээс: Хүн амаас	мян.төг	99785.2	100490.0	100.7
КаТВ-ийн сувагт холбогдсон хэрэглэгч	тоо	1270	1243	97.9
Телефон цэг	тоо	396	346	87.4

E-майл хаяг:

govisumber@nso.mn

Вэб хаяг:

govisumber.nso.mn

Мэдээллийн сангийн хаяг:

www.1212.mn

Утас:

70543222, 70543017